



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/331

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 186, 187 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03 албан даалгавар, "Хөдөө аж ахуйн болон төв суурин газрын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Сумдын хөдөө аж ахуйн болон төв суурин газрын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай танилцах удирдамжийг боловсруулан батлуулж, 2017 оны 10 дугаар сарын 02-оос 10 дугаар сарын 06-ны хооронд газар дээр нь очиж танилцан дүн мэдээг нэгтгэн 2017 оны 10 дугаар сарын 12-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн ажлын хэсгийн ахлагч /Ж.Мөнхчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200904